



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/А21

Булган сум

### “AIRAGDAY” намрын үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4, 23.1.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II Хуралдааны аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод “AIRAGDAY” намрын үзэсгэлэн худалдааны арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээнд шаардагдах 25,135,440 (хорин таван сая нэг зуун гучин таван мянга дөрвөн зуун дөч) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах” зардлаас санхүүжүүлэхийг сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4. “AIRAGDAY” намрын үзэсгэлэн худалдааны арга хэмжээг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган, чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг Ажлын хэсэг (Д.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
10 дугаар сарын 10-ны өдрийн 1/2023 дугаар  
захирамжийн хавсралт

“AIRAGDAY” АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр	Тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
<b>Арга хэмжээний зардал</b>				
1	Тог цахилгааны зардал	1 өдөр	350,000	350,000
2	Асар түрээслэх	16 ш	250,000	8,000,000
3	Ширээ түрээслэх	48 ш	20,000*2	1,920,000
4	Сандал түрээслэх	48 ш	5,000*2	420,000
5	Хулдаасан хэвлэл /сумд/	16 ш	22,000	352,000
6	Эх бэлтгэл	1 ш	220,000	220,000
7	Тайзны хэвлэл /6*3/	1 ш	198,000	198,000
8	Мандат /оролцогчид/	85 ш	2,200	187,000
9	Мандат /зохион байгуулагчид/	10 ш	3,300	33,000
10	Хог ачилтын зардал	2 өдөр	-	7,687,440
11	Айраг	200 л	7,700	1,540,000
12	5 литрийн сав	4 ш	2,000	8,000
13	Шатахууны зардал	165 л	3750	620,000
14	Бусад	-	-	1,500,000
<b>Дүн</b>				<b>23,035,440</b>
<b>Нээлтийн үйл ажиллагааны зардал</b>				
1	Тайз	1 өдөр	1,250,000	1,250,000
2	Хөгжим апартур 6 нүүр	1 өдөр	850,000	850,000
<b>Дүн</b>				<b>2,100,000</b>
<b>Нийт дүн</b>				<b>25,135,440</b>